



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
Е-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНД**

2020-17-20 № 132  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Баянжаргалан сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Баянжаргалан сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянжаргалан сумын Монгол ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-

0012020347


2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянжаргалан сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр / .б.. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

Хавсралт . .б. . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР

УРИА: “ ЖАРГАЛАН НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА ”

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, “Баянжаргалан 100” хөгжлийн хөтөлбөр, “Монгол Ардын Намын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилсан мөрийн хөтөлбөрийг 5 үндсэн бүлэг, 24 зорилт, 76 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМ НЬ:

1. Иргэний хөгжлийн бодлого
2. Сайн засаглалын бодлого
3. Хөдөө аж ахуйн бодлого
4. Эдийн засгийн бодлого
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлого

НЭГ.ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- Эрүүл иргэн
- Боловсролтой иргэн
- Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
- Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн
- Ажилтай, орлоготой иргэн
- Залуучуудын хөгжлийг дэмжинэ
- Ахмадын хөгжлийг дэмжинэ.
- Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ.
- Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- Мэргэшсэн чадварлаг төрийн алба
- Шилэн тендерийг зохион байгуулна.
- Хүнд сурталгүй -цахим Баянжаргалан
- Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.
- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- Малчдын амьжиргааг сайжруулна.
- Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.
- Бэлчээрийн менежментийг сайжруулна.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО



- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.
- Төр, хувийн хэвшлийн түншлэл.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

## ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

- Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.
- Суманд хийгдэх хөрөнгө оруулалт.

### 1.1 Эрүүл иргэн.

1.1.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.3 Малчин бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.4 Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилчдыг жил бүр шалгаруулж, эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.1.5 “Тэмбүү өвчний эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

### 1.2. Боловсролтой иргэн

1.2.1 Багшийн хөгжлийн төвийг тохижуулна.

1.2.2 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.2.3 Иргэдийн боловсролыг дээшлүүлэх, туршлага судлуулах хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.2.4 Дуу хөгжмийн өрөөг хөгжмийн зэмсэгээр хангаж, биеийн тамирын талбайг стандартын дагуу тохижуулна.

### 1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн

1.3.1 “Боржигин өв соёл”-ыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн сурталчилна.

1.3.2 Орон нутгийг судлах танхимыг бий болгож тохижуулна.

1.3.3 Сур, шагайн харвааг залуу хойч үед өвлүүлэх, сургалт зохион байгуулна.

1.3.4 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарыг олон нийтэд сурталчлан таниулах, тэдгээрийн авьяас чадварыг ирээдүй хойч үедээ сурган өвлүүлэх “Шавь сургалт”-ыг үе шаттайгаар зохион байгуулна.



## **1.4 Эрүүл, идэвхитэй амьдралтай иргэн**

1.4.1 Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Гудамж хорооллын тэмцээн”-ийг зохион байгуулна.

1.4.2 “Эрүүл идэвхтэй амьдрах клуб” бий болгоно.

1.4.3 Бие бялдар , идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр “Чийрэгжүүлэлт, аэробикийн клуб”-ийг бий болгох.

## **1.5 Ажилтай, орлоготой иргэн**

1.5.1 Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.5.2 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.5.3 Их дээд болон мэргэжлийн сургуульд суралцаж төгсөх залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцөлөөр хангана.

1.5.4 “Хүний нөөцийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

## **1.6 Залуучуудын хөгжлийг дэмжинэ**

1.6.1 Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулна.

1.6.2 Гэр бүл хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв өнгөрөөх сургалт, боловсролын төв байгуулна.

## **1.7 Ахмадын хөгжлийг дэмжинэ**

1.7.1 Ахмад настан, залуучууд, хүүхэд багачуудын гурван үеийн уулзалтыг зохион байгуулна.

1.7.2 “Ахмад насны хөгжил хамгааллын үндэс”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.7.3 Ахмадын өргөө барьж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

## **1.8 Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ**

1.8.1 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.

## **1.9. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил**

1.9.1 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, хурд сааруулагч, гэрлэн дохио, камертай болгоно.

1.9.2 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.9.3 Эмэгтэйчүүдийн товлот дархлаажуулалтыг нэвтрүүлж умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах “Энх Бүсгүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



## **2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба**

2.1.1 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяалалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

2.1.2 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.

2.1.3 Төрийн тусгай болон жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгон шалгаруулж нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

2.1.4 Авилгаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

## **2.2 Хүнд сурталгүй -цахим Баянжаргалан**

2.2.1 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн - нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.2 Иргэд, олон нийттэй харилцах мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төр иргэний эргэх холбоог сайжруулна.

## **2.3 Шилэн тендерийг зохион байгуулна.**

2.3.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

2.3.2 Сумын бүх төрийн байгууллагуудын “Шилэн данс”-ыг хөтлүүлж, мэдээллэнэ.

## **2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.**

2.4.1 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

2.4.2 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг жилд 50 га-аас доошгүй хийлгэх.

2.4 .3 Бичил уул уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлнэ.

## **2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

2.5.1 Сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдаж “Сумын хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.5.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хүргэнэ.

2.5.3 Хог хаягдлын менежментийг сайжруулна.



A handwritten signature in black ink, appearing to be the name "М. Оюун" (M. Oyun).

2.5.4 Сум хөдөөд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ургамал тариална.

2.5.5 Аргийн хадны байгалийн цогцолбор газарт “Нүгнээч ” жуулчны бааз байгуулна

### **3.1 Малчдын амьжиргааг сайжруулна.**

3.1.1 Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлж эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.1.2 Залуу малчдыг дэмжих зорилгоор бэлчээрийн даац, хороо бууцны зохистой хэрэглээг хангуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

### **3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

3.2.1 Малаас гарах бүтээгдэхүүн , арьс шир ноос ноолуурын бичил төслүүдийг хэрэгжүүлж үйлдвэр цехийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.2.2 “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим,хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

### **3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.**

3.3.1 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах ажлыг жил бүр зохион байгуулна.

3.3.2 Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, малын эмч, зоо техникчдийг бэлтгэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.3 Мал эмнэлэг үржлийн тасгийн үйл ажиллагааг дэмжиж машин техник хэрэгслээр хангана.

### **3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.**

3.4.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж бэлчээрт гүн өрмийн болон энгийн уурхайн худаг гаргана.

3.4.2 Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой байгальд халгүй энгийн механик арга болон микробиологийн аргыг хослуулан тэмцэж бэлчээрийг хамгаална.

### **4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ**

4.1.1 Орон нутгийн онцлогтой брэнд хүнсийг дотоод, гадаадын зах зээлд гарах, нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг суманд байгуулахыг дэмжинэ.

4.1.2 Туслах аж ахуй болон гахай, тахианы аж ахуй эрхлэх санал санаачилгыг дэмжинэ.

4.1.3 Сумын онцлогт нийцсэн жижиг дунд үйлдвэрлэлийн байр байгуулна.

### **4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.**

4.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагийн наадам г.м/-г сурталчлах.

4.2.2 Орон нутгийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин орлогыг нь нэмэгдүүлнэ.



4.2.3 Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4.2.4 Орон нутгийн үзэсгэлэнт газруудын тойрон аялах маршрут гарган хөтөчтэй болно.

#### **4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл**

4.3.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацын тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалт санхүүжилт татан, бичил бизнес эрхлэгч нарыг дэмжих хөтөлбөр боловсруулна.

4.3.2 “Баянжаргалан түншлэл” арга хэмжээг жил бүр зохион байгуулна

4.3.3 Төрийн болон орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж үр дүнд хүргэнэ.

#### **4.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.**

4.4.1 Сумын хэмжээнд нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандартад нийцсэн үйлчилгээний төв байгуулах санал санаачилгыг бүрэн дэмжинэ.

4.4.2 Стандартад нийцсэн ресторан, зочид буудал, супер маркетын салбар дэлгүүр байгуулах ажлыг эхлүүлнэ.

#### **5.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.**

5.2.1 Олон төрлийн /орлогод нийцсэн, түрээсийн, ногоон/ орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай сууцаар хангана.

5.2.2 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

5.2.3 Суманд “Шинэ Гудамж”, “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

#### **5.3 Суманд хийгдэх хөрөнгө оруулалт**

5.3.1 Соёлын төвийн барилга шинээр бариулна .

5.3.2 Нутгийн удирдлагын ордон спорт заалтай болно.

5.3.3 Ёслол хүндэтгэлийн өргөөтэй болно.

5.3.4. 40 айлын орон сууц бариулна .

5.3.5 “Сумын хөгжил”-ийн хүрээнд жишиг сум болж хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлнэ.

5.3.6 Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн гавьяат эдийн засагч Д.Моломжамцын нэрэмжит талбай барина.

